

МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

CAUSES, CONDITIONS, AND INFLUENCING FACTORS OF CORRUPTION-RELATED CRIMES IN MONGOLIA

О.Алтангэрэл

Монгол Улсын Их сургуулийн докторант

O.Altangerel

Doctoral student, National University of Mongolia
Law, UFE, Master of Laws (LL.M)

*хариуцлагатай зохиогч: altangerel@parliament.mn

Хураангуй: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол Улс дахь авлигын шинжтэй гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болон түүнийг бий болгож, түгээмэл болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийг олон талын үүднээс шинжилсэн болно. Хууль эрх зүй, улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын орчны нэгдсэн үнэлгээнд тулгуурлан авлигын бүтэц, тогтолцоо, түүний давтамжийг тодорхойлсон. Судалгааны үр дүнд төрийн байгууллагын институцийн чадавх сул байдал, ил тод байдлын хомсдол, улс төрийн ивээлд суурилсан тогтолцоо, хариуцлагын механизм хангалтгүй байх нь авлигыг тархах гол үндэс болж буйг тогтоов. Мөн орлогын ялгаа, эдийн засгийн төвлөрөл, төсөв, худалдан авалтын үйл ажиллагааны эмзэг байдал зэрэг эдийн засгийн хүчин зүйлс нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үүнээс гадна албан бус төлбөрийг “хэвийн” гэж хүлээн зөвшөөрөх нийгмийн хандлага, төрд итгэх итгэлийн түвшин доогуур байх зэрэг нь авлигыг өөгшүүлж буй соёлын орчинг бий болгодог. Судалгаа нь авлигын үндсэн шалтгааныг бууруулахад чиглэсэн хууль эрхзүйн цогц шинэчлэл, институцийн бие даасан байдлыг бэхжүүлэх, иргэний оролцоог нэмэгдүүлэх, шударга ёсны соёлыг төлөвшүүлэх шаардлагыг онцлон тэмдэглэв. Энэ нь Монгол Улс дахь авлигын тогтолцоот болон бүтцийн шалтгааныг гүнзгий ойлгоход хувь нэмэр оруулна.

Abstract: This research article examines the causes, conditions, and contributing factors of corruption-related crimes in Mongolia from a multidisciplinary perspective. Based on an integrated analysis of legal, political, economic, and socio-cultural contexts, the study identifies the structure, mechanisms, and frequency of corruption. The findings indicate that weak institutional capacity, lack of transparency, politically patronage-based systems, and insufficient accountability mechanisms constitute the primary foundations for the spread of corruption. Economic factors, including income inequality, economic concentration, and vulnerabilities in public procurement and budgeting, further exacerbate the risk of corruption. Additionally, social norms that accept informal payments as “normal” and low public trust in government institutions create a cultural environment that reinforces corrupt practices. The study highlights the necessity of comprehensive legal reforms, strengthening institutional independence, promoting civic engagement, and fostering a culture of integrity to reduce the underlying causes of corruption. Overall, the research contributes to a deeper understanding of the structural and systemic drivers of corruption in Mongolia.

Түлхүүр үгс: Авлига, Монгол Улс, засаглал, институцийн чадавх, ил тод байдал, хариуцлага, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс, авлигын эрсдэл, гэмт хэрэг.



Авлигын гэмт хэргийн
урьдчилсан
түгээмэл
болгоход
нөлөөлж
буй
хүчин
зүйлс



ᠭᠡᠮᠡᠲᠡ ᠶᠡᠳᠡᠯᠠᠨ ᠰᠠᠯᠲᠤᠭᠠᠨ

Keywords: Corruption, Mongolia, governance, institutional capacity, transparency, accountability, socio-economic factors, corruption risk, crime.

Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг нийгмийн мөн чанараас салангид авч үзэх боломжгүй бөгөөд хүн төрөлхтөн, нийгэм оршин байгаа цагт нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдал бодитойгоор оршоор байх болно. Гэмт явдлын шалтгаан нөхцөл нь криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахууны нэг бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлдөг нийгмийн өөрчлөлтийн явцад үүсэж буй цогц үзэгдлийн харилцан үйлчлэл юм.

Аливаа гэмт явдлын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүний чиг хандлагыг тогтоон тухайн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж, гэмт хэрэг үйлдсэн хүний хэв шинжийг тодорхойлсны дүнд урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион байгуулахын тулд тэдгээрийн чиглэл, хамрах хүрээг тодорхойлох нь зүйтэй.

Гэмт явдлын шалтгаан гэдэг нь гэмт хэрэгтэй удамшлын холбоотой, түүнийг үүсгэх, оршин тогтнохыг дэмжих, гэмт хэргийн гаралт нэмэгдэх, буурахад нөлөөлж буй үзэгдлийг хэлнэ. Нөхцөл байдал гэдэг нь шалтгааныг үүсгэдэг, эсхүл түүний үйл ажиллагааны боломжийг бий болгодог, өөрөөр хэлбэл, гэмт хэрэг байгаа эсэхийг тодорхойлдог үзэгдэл юм. Гэмт хэргийн нөхцөлийг дагалдах (үйл явдал, үзэгдлийн ерөнхий суурь, газар, цаг хугацааны нөхцөл байдлыг бүрдүүлдэг), шаардлагатай (ийм нөхцөлгүйгээр үйл явдал тохиолдох боломжгүй), хангалттай (зайлшгүй бүх нөхцөлийг бүрдүүлдэг) гэж ангилна. Харин хүчин зүйл нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлтэй үйл ажиллагааны уялдаа холбоотой байдаг хэдий ч, түүнийг үүсгэдэггүй, тодорхойлдоггүй үзэгдэл юм.

Аливаа юмс, үзэгдлийн нэгэн адил авлига нь нийгэмд тохиолдож буй үйл явц, үзэгдлүүдтэй учир шалтгааны харилцан хамааралтай байдаг. Улс төр, эрх зүй, нийгэм-эдийн засгийн салбарт хийж байгаа өөрчлөлт, шинэчлэлийг дагаад авлигын

гэмт хэргийн арга, хэлбэр мөн хувьсан өөрчлөгдөж байна.

Дэлхийн тэргүүлэгч шашнууд авлигын гэмт хэрэгтэй холбогдох харилцааг түүхийн аль ч шатандаа буруушаасаар ирсэн. Тухайлбал, Библид “Бэлгийг бүү ав, учир нь бэлэг нь харагчдыг сохор болгож, зөв шударга хүний ажлыг гажуудуулдаг” (Bible, 2001), Коран сударт “Бие биеийнхээ эд хөрөнгийг завшиж болохгүй, бусдын өмчийг зориудаар авахын тулд шүүгчдэд хахууль бүү өг” (Qur'an, 2008) хэмээжээ. Үүний зэрэгцээ, монголчуудын зан заншил, ахуй нөхцөлд нь хамгийн ойр байсан шашин болох буддизмын сургаал нь авлигатай тэмцэхэд чиглэсэн ёс суртахууны тодорхой зарчмуудыг агуулдаг. Буддистууд ёс суртахууныг ойлгох ухаан дутагдсан хүн авлигад шунадаг бөгөөд нийтийн өмчөөс хулгайлах, өөрт ашигтай байдлыг үүсгэж, бусдыг хохирооно гэдэг нь асар том нүгэл хэмээн, энэ нь тэдний зовлонгийн шалтгаан болдог гэж үздэг байна.

Авлигын гэмт явдал нь нийгэмд олон хүчин зүйлсийн нөлөөгөөр үүсдэг бөгөөд энэ нь улс бүрийн онцлогоос хамааран өөр хоорондоо ялгаатай байж болно. Авлига нь эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашиглах явдал бөгөөд энэ нь нийгмийн тогтвортой байдал, ардчилал, ёс зүй, шударга ёсонд сөргөөр нөлөөлдөг.

Авлигын гэмт явдлын шалтгааныг тал бүрээс тодорхойлсон эрдэмтдийн олон ургалч үзэл санаа байдаг хэдий ч, нийтлэг шалтгаан нь нийгмийн шинж чанартай гэдэгт санал нэгдэж байна. Хууль зүйн доктор, профессор В.Н.Кудрявцев өөрийн бүтээлдээ авлигын гэмт явдлын шалтгааныг эдийн засаг, улс төр, эрх зүй, сэтгэл зүйн болон удирдлага, зохион байгуулалтын (Герцик, 2016) гэж ангилж болно үзсэн бол, хууль зүйн доктор (Sc.D), профессор Максимов.С.В энэ гэмт явдлын шалтгааныг эдийн засгийн, улс төрийн, удирдлага, зохион байгуулалтын, сэтгэл зүйн гэж тус тус ангилсан байна (Максимов, 2017).

Авлигын гэмт явдал нь олон улсын болон үндэсний хэмжээнд нийгмийн хөгжлийг сааруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулах, шударга ёсыг гажуудуулах зэрэг сөрөг үр дагавартай.

Авлигын гэмт явдлыг хүрээгээ тэлэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг олон талт хүчин зүйл байдаг бөгөөд олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмж, Монгол Улс дахь авлигын гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн энэ гэмт явдлын үндсэн шалтгааныг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

Хууль зүйн шалтгаан. Гадаад улсын болон үндэсний хэмжээнд гүйцэтгэсэн социологийн судалгааны үр дүнгээс үзэхэд, авлигын гэмт явдалтай тэмцэх тогтолцооны боловсронгуй бус байдал энэ гэмт явдлын голлох шалтгаан болж байна.

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Зургаа дахь хэсгийн “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана” гэж зорилт, арга хэмжээ тусгажээ.

УИХ-аас 2002, 2016, 2023 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” жил болгон зарлаж, Монгол Улсын хөгжлийг сааруулж буй гол асуудал болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч олон улсын тавцан дахь манай улсын авлигын гэмт хэрэгтэй тэмцэж

буй тэмцлийн үнэлэмж хангалтгүй байсаар байна.

Улс орны авлигын түвшинд нөлөөлдөг гол хүчин зүйлийн нэг бол хууль дээдлэх ёсны хэрэгжилт юм. Мөн тухайн улсын авлигын түвшин, эрсдэлийг хэмжихэд олон улсын байгууллагуудын ашигладаг чухал үзүүлэлт бол Дэлхийн эрх зүйн төсөл (World Justice Project) байгууллагаас гаргадаг “Хууль дээдлэх ёсны индекс” (World Justice Report, 2024) юм. Энэ индекс нь төрийн эрх мэдлийн хязгаарлалт, авлигаас ангид байдал, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хүний үндсэн эрх, эрүүгийн болон иргэний хэргийн шүүн таслах ажиллагаа зэрэг 8 багц, 44 дэд үзүүлэлтийг хэмжиж 0-1 оноогоор үнэлдэг. Манай улсын хувьд 2015 оноос хойш тогтмол 0.53-0.55 оноогоор үнэлэгдсэн (АТГ, 2023) бөгөөд олон улсын байгууллагаас манай улсыг уг 44 дэд үзүүлэлтэд заасан ажлын эрчимжүүлэх шаардлагатай талаар зөвлөмж өгчээ.

Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэхийн тулд нийгэмд энэхүү сөрөг үзэгдлийн талаар цогц ойлголтыг хэвшүүлэх нь зүйтэй байдаг. Иргэд, олон нийт өөрт учирч буй тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхээр төрийн байгууллага, албан тушаалтанд хандахдаа, тухайн харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт, өөрийн эрх, үүргийн талаарх мэдлэг дутмаг байгаа нь энэ гэмт явдалтай тэмцэхэд сөргөөр нөлөөлж байж болзошгүй.

Удирдлага, зохион байгуулалтын шалтгаан. Гадаад улсын болон дотоодын эрдэмтдийн үзэл, санаа, авлигатай тэмцэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлох чиглэлээр туурвисан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдэд энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нь түүний бүтэц, чиглэл, салбараас үл хамааран шүүх эрх мэдэл, хууль хяналтын байгууллагаас удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын хангалтгүй үр дүн гэж тодорхойлсон байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний



ХҮҮЛЬ ДЭЭДЛЭХ



ᠮᠣᠩᠭᠣᠯᠤᠯᠤᠰ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

чанар үр дүн хангалтгүй, мөн үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын алба хаагчид энэ төрлийн гэмт хэрэг холбогдож буй байдлаас шалтгаалан төрд итгэх иргэд, олон нийтийн итгэл буурч байна.

Зарим криминологчид, авлигын гэмт явдлын тодорхой шалтгааныг шүүх эрх мэдлийн тогтолцооны сул дорой байдал, тухайн байгууллагуудын улс, иргэд олон нийтийн хууль ёсны эрх ашгийн төлөө бус, тодорхой нэгэн албан тушаалтны хууль бус шийдвэрийг хамгаалж буй байдал хэмээн тодорхойлсон байна.

Доктор (Ph.D) В.А.Макаровын 2023 онд хийсэн судалгаагаар авлигын гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд, нийтийн албан тушаалтны үйл ажиллагаа, орлогод тавих хяналт хангалтгүй (23.5%), төрийн албан хаагчдын цалин бага (15.4%), авлигын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогын оновчгүй байдал (14%) гэж үзжээ. Түүнчлэн, авлигыг бий болгож буй шалтгааны нэг нь олон нийтийн зүгээс тавих хяналт сул, тухайн улсын уламжлалтай хамааралтай гэжээ.

Авлигын гэмт явдал нь ихэвчлэн төрийн байгууллагуудын дотоод зохион байгуулалтын алдаа, хяналтын системийн сул байдлаас үүдэлтэй. Хяналт, шалгалтын механизм хангалтгүй, сул хяналттай системүүд нь авлигын гэмт явдал үйлдэгдэх таатай нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхгүй байх нь авлигатай тэмцэх ажлын үр дүнг сулруулдаг тул хууль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхээс гадна, иргэд, олон нийтийн санал бодлыг сонсох, тэдний оролцоог нэмэгдүүлэх, мөн Авлигатай тэмцэх газар болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь чухал юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал бол гагцхүү хууль сахиулах байгууллагын онцгой эрх юм гэсэн нэлээд өргөн тархсан үзлийг криминологичид няцаасаар ирсэн. Төрийн нэгдсэн тогтолцоо, иргэний нийгмийн оролцоогүйгээр энэ төрлийн

гэмт хэргийн гаралтыг бууруулах боломжгүй.

Иймд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар төрийн байгууллагуудын шударга байдлыг бэхжүүлэх зорилгоор олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Мөн авлигатай тэмцэх үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах нь энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт болон түүнд тавих хяналтыг сайжруулахад тусална. Шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх замаар авлигатай тэмцэх үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох боломжтой гэж үзэж байна. Үүний зэрэгцээ, иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах, иргэний нийгмийн байгууллагуудын идэвх санаачилгыг дэмжих нь авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулахад чухал ач холбогдолтой (ХЗҮХ, 2021).

Эдгээр арга хэмжээ нь авлигын гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын удирдлага, зохион байгуулалтад нөлөөлөх гол хүчин зүйл бөгөөд тэдгээрийг шийдвэрлэх нь нийгмийн шударга ёсыг хангах үндэс суурь болно.

Улс төрийн шалтгаан. Авлигын гэмт явдал үүсэх гол шалтгаануудын нэг нь улс төрийн шалтгаан, тэр дундаа улс төрийн тогтолцооны сул тал юм. Үүнд: эрх мэдлийн төвлөрөл, хяналт, тэнцвэрийн механизмын сул байдал, улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод бус байдал, төрийн албаны мерит тогтолцооны боловсронгуй бус хөгжил зэрэг хамаарах бөгөөд эдгээр нь авлига үүсэх таатай орчныг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ, улс төрийн соёлын асуудал, ёс зүйн доройтол нь авлигын гэмт явдал үйлдэгдэхэд нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна. Тухайлбал, улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээний доголдол, танил тал, хамаатан саднаа дэмжих үзэл, нийтийн эрх ашгаас илүү хувийн ашиг сонирхлыг дээдлэх хандлага нь нийгэмд авлигыг хүлээн зөвшөөрөх хандлага төлөвшихөд ихээр нөлөөлж байна.



Мөн энэ гэмт явдалтай тэмцэхэд үйл ажиллагааны үр дүнг бууруулж буй хүчин зүйлийн нэг нь улс төрийн тогтворгүй байдал юм. Монгол Улсад 1990 оноос хойш улс төрийн тогтворгүй байдал газар авч, Засгийн газрын ажиллах дундаж хугацаа богиноссон. Энэ нь улс төрийн шийдвэр гаргалтын үйл ажиллагааг удаашруулж, бодлогын тогтвортой байдлыг алдагдуулдаг сөрөг нөлөөтэй. Мөн сонгуулийн дараах төрийн албан хаагчдын томилгоо, тогтолцооны өөрчлөлт нь төрийн албаны мэргэшсэн байдал, залгамж чанарыг алдагдуулж, улмаар ардчилсан ёсонд зүй бус нөлөөг үзүүлж байна.

Авлигын эсрэг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газрыг байгуулж 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Түүнээс хойш 17 жилийн хугацаа өнгөрсөн хэдий ч авлигын индексээрээ урагшаа ахих биш хойшоо ухарсаар байна. Энэ нь авлигатай тэмцэх ажил нь ердөө л хэлбэр төдий байсныг олон улсын авлигын индекс баталж байна. Манай улс авлигын индексээр унах болсон шалтгаан нь төрийн институцүүдийн улс төрийн намаас хараат байдал, авлигын хэрэгт холбогдож, буруутайгаар тогтоогдсон гэмт

хэрэгтнүүдийг ял оногдуулахгүй, гэмт хэргийг шийдвэрлэлгүй замхруулдаг явдалтай холбоотой юм. Үүнээс шалтгаалж улсад учирсан олон их наяд төгрөг эргэн төлөгдөхгүй байгаа нь иргэдийг авлигын эсрэг тэмцэлд итгэл алдрахад хүргэсэн байна (Алтангэрэл, 2024).

Эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг бууруулж, гэм буруутанд хариуцлага тооцдог тогтолцоог бэхжүүлж, хил дамнан урсах авлигын хөрөнгө, мөнгийг хөдөлгөж буй албан тушаалтанд хариуцлага тооцдог болох ёстойг 2017 онд Транспэрэнси Интэрнэшнл Монгол байгууллагаас сануулсан. Нөгөөтгээгүүр, популист улстөрчдийн хоосон амлалтад хууртахгүй байх нь том дэвшил аж. Популист улс төрчид ардчиллыг үгүй хийж, шүүхийн хараат бус байдлыг уландаа гишгэж, авлигыг нарийн техниктэйгээр газар авахуулдаг хэмээн олон улсын байгууллага дүгнэжээ.

АНУ-ын Кларемонтын их сургуулийн профессор Роберт Клитгаард олон жил авлигын гэмт хэргийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үр дүнд авлигын томьёог боловсруулжээ. Тухайн томьёонд тэрээр өөрийн үзэл санааг бүхэлд нь багтаасан байна.

“Corruption = monopoly + discretion – accountability” (Klitgaard, 1998) буюу

“Авлига = монопол + үзэмж – хариуцлага”

Түүний тодорхойлсноор аливаа эрх мэдэлтэй хүнд сонголт хийх эрх нэмэгдэж, түүнд аливаа асуудлыг шийдвэрлэх үзэмж нөлөөлж, тухайн үйлдэлд хүлээх хариуцлага, ил тод байдал алга болоход авлига үүсдэг гэж тодорхойлсон байна.

Уг томьёонд зарим эрдэмтэд “Монопол байдал болон сонголт хийх боломж их, ил тод байдал хангалтгүй үед авлига өөрөө бий болохгүй. Авлига үүсэхэд ёс суртахууны үзүүлэлт голлох нөлөө үзүүлдэг гэж үзэж Р.Клитгаардын томьёог дараах байдлаар өөрчилсөн байдаг.

“Авлигын хэмжээ = монопол + сонголт хийх боломж – ил тод байдал-ёс суртахуун”

Иймд авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд улс төрийн тогтолцоог боловсронгуй болгох, эрх зүйн орчныг сайжруулах, төрийн болон иргэдийн хяналтыг дээшлүүлэх, улс төрийн соёлыг төгөлдөржүүлэх зэрэг цогц арга хэмжээ авах шаардлагатай юм. Мөн авлигагүй нийгэм, шударга төрийг байгуулахын тулд иргэдийн боловсрол, ёс

зүй, болон нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх нь чухал ач холбогдолтой гэж бид үзлээ.

Эдийн засгийн шалтгаан. Монгол Улсын түүхэн хөгжлийн аль ч цаг үед авлигын гэмт хэрэг байсаар ирсэн хэдий ч 1990-ээд оны нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үеэр, Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэний улмаас энэ төрлийн



Хууль сахиулахуй

гэмт хэргийн гаралт огцом өссөн. Төрийн хяналт суларсантай холбоотойгоор төрийн өмчийг хяналтгүйгээр бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хувьчлах, бусдыг далайлан сүрдүүлэх буюу “рәкет” гэмт хэрэг үйлддэг, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн тоо өсөн, нэмэгдэж, үүний зэрэгцээ авлигын гэмт хэргийн гаралт урьд өмнө байгаагүйгээр ихэссэн. Тухайн үеэс эхлэн нийгэмд авлигыг эдийн засгийн амжилтын гол хүчин зүйл, улс төрд нөлөөлөх хэрэгсэл гэж үзэх хандлага эхэлсэн.

Зах зээлийн энэхүү өөрчлөлт нь Монгол Улсад далд эдийн засгийг бий болгоход хүргэсэн бөгөөд үүнээс шалтгаалан авлигын гэмт явдал мөн хурдацтайгаар хөгжсөн. АНУ-ын судлаач Smith P. 1994 онд гүйцэтгэсэн “Далд эдийн засгийн хэмжээг үнэлэх нь: Канадын статистикийн чиг хандлага” сэдэвт судалгаандаа сүүдрийн буюу далд эдийн засгийг “ДНБ-ий албан ёсны тооцооноос зайлсхийсэн хууль ёсны болон хууль бус бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд суурилсан үйлдвэрлэл” (Smith, 1994) гэж тодорхойлон ашиглажээ. Улс орны эдийн засгийн тооцоонд орох ёстой боловч нуугдмал, хууль бус, албан бус үйл ажиллагааны улмаас, эдийн засгийн албан ёсны статистикийн мэдээллээс орхигдсон үйл ажиллагааг нийтэд нь “Далд буюу сүүдрийн эдийн засаг” хэмээн нэрлэдэг. Хөгжиж буй улсуудын далд эдийн засгийн дундаж хэмжээ 30-40 хувь байдаг бөгөөд гадаад улсын судалгааны байгууллагуудын тодорхойлсноор Монгол Улсын далд эдийн засгийн хэмжээ 2000-2005 онд 13.9%, 1999-2007 онд 17.6%, 1996-2014 онд 18.4%, 1991-2015 онд 17.2%-тай байна. Харин Үндэсний статистикийн хорооноос 2018 онд гаргасан судалгаагаар 2018 онд далд эдийн засгийн хэмжээ 9.2%-тай байна гэжээ.

Үүний зэрэгцээ, зарим судлаачид төрийн албан хаагчдын цалин, хангамж бага байгаа нь авлигын гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн нэг шалтгаан гэж онцолсон хэдий ч энэ нь маргаантай асуудал юм.

Байгууллагын шалтгаан. Монгол Улсад үйлдэгдэж буй авлигын гэмт хэргийн

шалтгааны нэг нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод бус байдал юм. Төрийн бодлогын хэмжээнд цахим засаглалын тогтолцоог бий болгох замаар энэ сөрөг хүчин зүйлийг арилгах оролдлого хийж байгаа боловч, цахимжилтийг улам төгөлдөржүүлэх шаардлага байсаар байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-гийн Засаглалын зорилтуудын шалгуур үзүүлэлтэд Дэлхийн банкны Дэлхийн засаглалын 5 үзүүлэлтээс гадна НҮБ-ын Цахим засгийн хөгжлийн индексийг ашиглахаар заасан (АТГ, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, 2023).

НҮБ-аас улсуудын “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ийг хоёр жил тутамд шинэчлэн тодорхойлдог. Энэхүү индексээр Монгол Улс 2018, 2020 онд НҮБ-ын гишүүн 193 орноос 92 дугаар байрт, 2022 онд 18 байраар урагшилж, 74 дүгээр байрт орж байсан бол цахим харилцаа, холбооны дэд бүтцийн хөгжил, төрийн явуулж буй цахим үйлчилгээний тоо, иргэдийн цахим ур чадварын үзүүлэлт, хүний нөөцийн хөгжил, иргэдийн цахим оролцоо, эрх зүйн орчин, тухайн улсын урт хугацааны бодлого, дижитал хөгжлийн бодлого, стратеги, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлсний үр дүнд 2024 онд 28 байраар урагшилж, 46 дугаарт эрэмбэлэгджээ (ЦХИХХЯам, 2024). Мөн Цахим үйлчилгээний индекс (Online service index) 2020 онд 0.5294 бол 2022 онд 0.6263, 2024 онд 0.8222 болж огцом өссөнөөр 193 орноос 37 дугаар байрт оржээ.

Гэсэн хэдий ч, Монгол Улсад цахим засаглалыг хөгжүүлэхэд саад болж буй зарим бэрхшээл байна. Үүнд:

1) Алслагдсан аймаг, сумдад өндөр хурдны интернэтийн сүлжээ нэвтрээгүй, зарим сумд огт үгүй, тэдгээрийг зохион байгуулах санхүүгийн боломж хомс;

2) Төрийн албан хаагчдын, тэр дундаа ахимаг насны албан хаагчдын мэдээллийн технологитой ажиллах шаардлагатай ур чадвар дутмаг, “хуучин хэв маягаар” ажиллах хүсэл;

3) Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцийн зардал өндөр, түүний хөгжлийн удаашралтай байдал;

4) Цахим үйлчилгээг сурталчлах түвшин бага, ийм үйлчилгээг авахын тулд цахим гарын үсгийг иргэд ховор ашигладаг зэрэг болно.

Доктор Н.Б. Верхова хэлэхдээ, “Цахим ардчиллыг цогцлооход хүн амын тодорхой ангилал оролцохгүй байх гэсэн эрсдэлийг үнэлэх шаардлагатай байна (Верхова, 2020)” гэсэнтэй санал нэг байна.

Мэдээллийн ил тод байдал нь төрийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, төсвийн зарцуулалт зэрэг олон салбарт иргэдийн хяналтыг хангах нь авлигын эрсдэлийг бууруулахад чухал үүрэгтэй. УИХ-аас 2011 онд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг баталсан бөгөөд энэ хууль нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод болгох, иргэдийн мэдээлэл авах эрхийг хамгаалах зорилготой.

Ёс суртахууны шалтгаан. Авлигаас ангид нийгмийг цогцлоохын тулд ёс зүйг нийгэм, хувь хүн, байгууллагын хэмжээнд төлөвшүүлэх шаардлагатай. Авлигын гэмт явдлыг эрдэмтэн, судлаачид ёс суртахууны үнэт зүйлийн зөрчилдөөний онолын үүднээс тайлбарласан байдаг.

Ёс суртахууны үнэт зүйлийн зөрчилдөөний онолыг үндэслэгч Аристотель “Ethos” гэсэн үгийг анх хэрэглэж, хүний зан төлөвийн өвөрмөц шинжийг тодорхойлсон. Түүний үзэл баримтлалд ёс зүй нь зөвхөн сайн үйлийг гүйцэлдүүлэх тухай ойлголтоос гадна, энэ нь хүмүүсийн хоорондын харилцааг ч тодорхойлдог гэж үзсэн байна (Ёс зүй, 2014). Энэхүү онол нь хүний зан төлөв, нийгмийн харилцаа, эрх зүй болон соёлын хэм хэмжээ зэрэг хүчин зүйлийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм.

Ёс зүй гэдэг нь нийгмийн тодорхой тогтолцоонд хүмүүсийн зан авир, харилцан хамаарлыг тохируулахын тулд жам ёсоор бий болсон хэм хэмжээний цогц юм. Энэ нь хувь хүний зан чанар, сайн талууд болон хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээг хамардаг. Ёс зүйн зарчмууд нь хүмүүсийн амьдралын хэв маяг, нийгмийн

харилцаанд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь шударга, ёс зүйтэй нийгмийг бүрдүүлэхэд голлох байр суурийг эзэлнэ.

Зөрчилдөөний онол. Ёс суртахууны үнэт зүйлийн зөрчилдөөн нь тухайн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны зарчмуудын хоорондох ялгаа, эсхүл хувь хүний дотоод сэтгэлгээний зөрчилдөөнөөс үүдэлтэй байдаг. Энэ нь хүмүүсийн шийдвэр гаргах явцад үүсдэг бөгөөд хувь хүн өөрийн үнэт зүйл болон нийгмийн хүлээлтүүдийн хооронд тэнцвэр олох шаардлагатай болдог (Александр Берзин, 2023).

Ёс суртахууны үнэт зүйлийн зөрчилдөөний онол нь ёс зүйн философийн нэг чухал хэсэг бөгөөд энэ нь хүмүүсийн зан төлөв шийдвэр гаргалт болон нийгмийн харилцаанд нөлөөлөх нөлөөллийг судалдаг. Энэ онолын хүрээнд зөрчилдөөний асуудлууд, ёс суртахуун, эрх зүй, соёлын хэм хэмжээ зэрэг хүчин зүйлийг авч үздэг. Ёс суртахуун гэдэг нь аливаа хүний шийдвэр гаргалтад нөлөөлж буй зан байдлын хэм хэмжээ, зарчим юм. Энэ нь сайн (эсвэл үнэн зөв) ба муу (эсвэл худал хуурмаг) гэсэн ойлголтын хоорондох ялгааг тодорхойлдог бөгөөд зөрчилдөөний онолын үндсэн санааг тайлбарлаж болно. Нэгдүгээрт, үүрэг, хариуцлагад суурилсан ёс зүйг илэрхийлдэг Деонтологийн онол бөгөөд энэхүү онол нь зөв үйлдэл нь тухайн үйлдлийн үр дагавраас үл хамааран зөв гэсэн үзэл санаа юм. Хоёрдугаарт, утилитаризм буюу үр дүнд суурилсан ёс зүйн онол бөгөөд аливаа үйлдэл нь хамгийн олон хүнийг аз жаргалтай болговол зөв гэж үздэг.

Механик материализм, субъектив идеализмын алинаас ч өөрөөр социал зан үйлийн детерминацийн онцлогийг францын социологич Э.Дюркгейм анх үндэслэсэн. Э.Дюркгейм “аль ч нийгэмд хүн төрөлхтөн адилхан боловч, тэдний хүсэл, шунал, ёроолгүй тэнгис мэт төгсгөлгүй, хил хязгааргүй” гэжээ. Үүнээс гадна, тодорхой хэрэгцээгээ хангасны дараа ч хүнд илүү их, илүү тансаг, илүү өндөр түвшний амьдралын хэв маягийг хүсэх хүсэлд хязгаарлах ямар ч органик, психологийн, гадны хүчин зүйл байхгүй





МОНГОЛЫН ХУУЛЬ
САНХҮҮГИЙН
ХЭМЖЭЭНД
ЭС ЗҮЙГ
ӨНДӨР
ТҮВШИНД
ТӨЛӨВШҮҮЛЭХ
ТЭРГҮҮЛЭХ
ЗОРИЛТ
МОН ГЭЖ БИД ҮЗЛЭЭ.

юм. Гэсэн хэдий ч Дюркгеймийн үзсэнээр энэ хязгаарлагч нь ёс суртахууны ба хүндэл хүлээхүйц авторитар шинжтэй байх хэрэгтэй (Дашгаадан, 2022).

Дээрхээс үзэхэд, авлигын гэмт хэрэг нь нийгмийн аль ч салбар, хувь хүнд нөлөөлөх эрсдэлтэй бөгөөд авлигын шинжтэй нөхцөл байдалтай тулгарч, тодорхой шийдвэр гаргах үед аливаа хүний дотоод мөн чанар, ёс суртахууны зөрчилтэй тулгардаг. Иймд авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд хувь хүний, байгууллагын, нийгмийн хэмжээнд ёс зүйг өндөр түвшинд төлөвшүүлэх тэргүүлэх зорилт мөн гэж бид үзлээ.

Нийгмийн шалтгаан. Монголын нийгэмд авлигыг бий болгож буй үндсэн шалтгааны нэг бол нийгмийн баян, ядуугийн ялгаатай байдал юм.

Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктай хамтран гүйцэтгэсэн ядуурлын түвшин тогтоох судалгаагаар 2022 оны байдлаар Монгол Улсын ядуурлын түвшинг 27.1% гэж тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, 2022 оны байдлаар 914.2 мянган хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй буюу ядууралд өртсөн байна гэсэн үр дүн гарсан байна. Дээрх тоон үзүүлэлтийг суурьшлаар нь авч үзвэл, нийт ядуу иргэдийн 57 хувь нь хотод, 43 хувь нь хөдөө амьдарч байна. Нийт ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй иргэдийн 37 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байх буюу ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 5 хүн тутмын 2 нь Улаанбаатар хотод амьдарч байна (ҮСХ, 2022). Улс орны ядуурлын түвшин өндөр байгаа нөхцөл байдал нь нийгмийн салбар дахь авлигын деформацид хүргэдэг.

Зарим тохиолдолд ажил эрхлэлт, цалин хөлс, амьжиргааны эх үүсвэргүй үлдэх айдас нь иргэдийг авлигын схемд санаатайгаар оролцоход ихээхэн түлхэц болдог. Өөрөөр хэлбэл, санхүүгийн хүндрэлтэй байгаа хүмүүст авлигын гэмт хэрэг үйлдэх сэдэл, зорилго төрдөг байна.

Үүнээс гадна, авлигын гэмт хэргийн шалтгаан нь иргэд, олон нийт авлигыг “хэвийн зүйл” мэт хүлээн авч, дасах үйл явц юм. Нийгэм дэх авлигад хайхрамжгүй хандах хандлага нь хүмүүсийн өөрийгөө

үнэлэх үнэлэмжийг сулруулж, тэгш бус байдлыг тэсвэрлэх чадвараас үүдэлтэй. Төр нь ёс суртахууны үнэт зүйлс, шударга ёсны мэдрэмжийг нийгэмд төлөвшүүлэхийн тулд тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэггүйгээс материаллаг байдал нь хүний амьдралын дээд үнэт зүйл мөн гэсэн үзэл санаа залуучуудын дунд тархаж байгааг ажиглаж болно.

ОХУ-ын “Левада” судалгааны төвөөс 2019 онд гүйцэтгэсэн “Ядуурал авлигыг бий болгодог” сэдэвт судалгаагаар залуучууд Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлыг үр дүнтэй гэдэгт итгэхээ больсон” гэж хариулсан бөгөөд залуучуудын дунд “Төр хүн амын олонх хэсгийг анхаарч үздэггүй” гэсэн хандлага бий болсон талаар дурджээ.

Дээр дурдсанаас үзэхэд, нийгмийн сөрөг үзэгдэл болох авлигын гэмт явдал нь өндөр хөгжилтэй, хөгжингүй, баян, ядуу зэргээс үл хамааран дэлхийн бүхий л улсад тохиолддог байна. Транспаренси Интернэшнл олон улсын байгууллагаас гаргасан авлигын индексээр Монгол Улс 180 орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь олон улсын тавцанд манай улсын авлигын талаарх таагүй дүр төрхийг бүрдүүлж байгаа бөгөөд улсын хэмжээнд авлигатай тэмцэх тогтолцоог бүрдүүлэхэд хүндрэл учруулж буй эдийн засаг, институт, нийгмийн шалтгаанууд байсаар байна.

Мөн авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэхийн тулд иргэдийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн авлигын хор уршгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх нь энэ гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааны үр дүнд ахиулна.

Сэтгэл зүйн шалтгаан. Нийгэмд авлигаас ангид байх, энэхүү сөрөг үзэгдлийг үл тэвчих, авлигагүй нийгмийг цогцлооно гэсэн хүлээлт нийгэмд бүрдэхгүй үед хүмүүс авлигад оролцох магадлал нэмэгддэг. Үүний тулд, төрөөс авлигын гэмт явдалтай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, үүнд иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд авлигатай тэмцэх механизм сул байх нь авлигыг дэмжих сэтгэл зүйг нийгэмд төлөвшүүлдэг.



Авлигын гэмт явдлын голлох шалтгааны нэг нь сэтгэл зүйн шалтгаан бөгөөд авлига нь эхлээд хүмүүсийн ухамсарт бүрэлдэж, дараа нь тодорхой үйлдлээр илэрдэг. Авлигын сэтгэл зүйн шинж, авлигад хандах хандлага нь гурван чухал шинжээр тодорхойлогдох бөгөөд эдгээр нь олон нийтийн сэтгэл зүйтэй шууд холбоотой байдаг.

Нэгдүгээрт, хүлцэх шинж – энэ нь “тэд хулгайлдаг”, “тэд бүгдийг нь давуу байдлаар өөртөө авдаг” гэх мэтээр хүлээн авах хандлага бөгөөд иргэд сэтгэхүйдээ авлигыг арилгах боломжгүй зүйл, байж л байх үзэгдэл мэтээр хүлээн авч хэвшсэн байдал юм.

Хоёрдугаарт, олон нийтийн ухамсарт буруутгаж байгаа зүйл нь авлигын үйлдэл бус, их хэмжээний хээл хахууль буюу авлигын гэмт хэргийн мөнгөн дүнд байдаг байна.

Гуравдугаарт, үл нийцэх байдал, зөрчилдөөн. “Би болон миний хүрээлэл – бусад”. Авлигын гэмт хэрэг үйлддэг хүний ойр дотны хүмүүсийн сэтгэлгээ нь мөн ижил, “Өгөхгүй бол бүтэхгүй, авахгүй бол явахгүй” хандах хандлагатай байдаг байна.

Олон жилийн турш манай улсад бүрэлдсэн түүх, соёл, уламжлалын хэвшмэл байдал, онцлог нь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх таатай орчныг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, албан бус нийгмийн харилцааг албан ёсныхоос, “хууль бус” харилцааг “хууль ёсны” харилцаанаас илүүд үзэх явдал юм.

Монголын нууц товчоонд: “Тэмүүжин Тоорил ванд очиж булган дах өгч, Тоорил ван “Бутарсан улсыг цуглуулж өгье” (Дамдинсүрэн, 1990) гэж төр-улсын цэргийг хөдөлгөсөн талаарх түүхийн эх сурвалжаас үзэхэд, энэ сөрөг үзэгдэл нь эрт дээр үеэс бидэнтэй хамт оршсоор ирсэн гэж үзэж болохоор байна.

Төрөөс авлигын эсрэг нийгэм рүү чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэхгүй авлигын хүлээн зөвшөөрсөн энэ сөрөг үзэл санаа нь цаашид уламжлагдан, дамжиж “хэрэгтэй” хүмүүстэй нөхөрлөх гэсэн санааг амьдралын хэв маяг болгохыг илүүд үзсэн залуу хойч үе бий болж байна.

Иймд, авлигаас ангид байх, авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлэх, авлигын хор уршгийг олон нийтэд таниулах, хувь хүний ёс суртахууны боловсролыг системтэйгээр олгох нь энэ гэмт явдалтай тэмцэхэд нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажил юм.

Авлигын гэмт явдал нь улс төрийн, удирдлага, зохион байгуулалтын, эдийн засгийн, нийгмийн, байгууллагын, ёс суртахууны, сэтгэл зүйн зэрэг шалтгааны улмаас үйлдэгддэг байх бөгөөд урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг дээрх чиглэлээр, оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дүгнэлт

1. Авлигын гэмт явдлын нь хууль зүйн, улс төрийн, удирдлага, зохион байгуулалтын эдийн засгийн, нийгмийн, байгууллагын, сэтгэл зүйн, ёс суртахууны шалтгаантай байна. Авлигын гэмт хэргийн гаралт Монгол Улсад дараагийн 10 жилд тогтмол өсөх хандлагатай байх бөгөөд авлигатай тэмцэх стратеги боловсруулах, улс төрийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн болон иргэд, олон нийтийн хяналтыг сайжруулах, авлигын индексийг ахиулах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, нийгмийн сэтгэл зүй дэх авлигын асуудалд хандах хандлагыг өөрчлөх, ёс зүйг төлөвшүүлэх зэргээр энэ төрлийн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг оновчтой төлөвлөн, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Авлигын гэмт явдлын шалтгааныг эрдэмтэд олон талаас тайлбарласан байх боловч нь голлох шалтгааныг нийгмийн шалтгаан гэдэгт санал нэгдсэн байна. Иймд нийгмийн сэтгэл зүйд авлигыг үл тэвчих, авлигын эсрэг хандлагыг төлөвшүүлэх, энэ чиглэлээр иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлж, ёс суртахууны төлөвшилийг хэвшүүлэх шаардлагатай байна.

3. Монгол Улсад авлигын гэмт хэрэг үүсэх, тархах шалтгаан нь зөвхөн хувь



МОНГОЛЫН ХУУЛЬ ЗАСАГ

хүний үйлдэлтэй хамааралтай бус, харин институцийн хэврэг байдал, улс төрийн тогтолцооны сул тал, эдийн засгийн төвлөрсөн бүтэц, нийгмийн хэвшмэл ойлголт зэрэг олон хүчин зүйлийн нийлмэл нөлөөнд оршиж байна.

4.Төрийн байгууллагуудын ил тод байдал хангалтгүй, хариуцлагын тогтолцоо сул, бодлого хэрэгжүүлэх байгууллагын бие даасан байдал дорой байгаа нь авлигын үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн орлогын тэгш бус байдал, нөөц баялгийн хэт төвлөрөл, төсөв болон худалдан авалтын үйл явцын ил тод бус бүтэц нь авлигыг санхүүгийн болон байгууллагын түвшинд өөгшүүлж байна. Нийгмийн түвшинд албан бус төлбөрийг зөвшөөрөх, төрд итгэх итгэлийн бууралт зэрэг нь авлигыг хэвийн үзэгдэл мэт болгож, соёлын орчныг сулруулдаг. Иймээс авлигын үндсийг зөвхөн хууль зөрчсөн хувь хүний асуудал гэж бус, бүтцийн, тогтолцооны шинжтэй асуудал хэмээн ойлгож, олон талт бодлогоор шийдвэрлэх шаардлагатай.

Санал

- Хяналт, шалгалтын байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлж, улс төрийн нөлөөллөөс ангид ажиллах орчин бүрдүүлэх;

- Төрийн албан хаагчдын томилгоог мерит зарчимд тулгуурласан ил тод, шударга болгох;

- Төсөв, төрийн худалдан авалтыг бүрэн цахимжуулж, нээлттэй мэдээллийн стандартыг мөрдүүлэх;

- Албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг ил тод, олон нийтэд хялбар нэвтрэх боломжтой хэлбэрээр шинэчлэх;

- Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой зөрчлийн хариуцлагыг нэмэгдүүлэх;

- Авлигын хор нөлөө, шударга ёсны үнэ цэнийг өсгөх чиглэлтэй боловсрол, олон нийтийн мэдээллийн хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх;

- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дотоод хяналт, мэдээлэгчийн хамгааллын тогтолцоог сайжруулах;

- Нүүрс, ашигт малтмал зэрэг томоохон салбарын орлого, гэрээг ил тод

болгох олон улсын стандартыг хэрэгжүүлэх;

- Жижиг, дунд бизнесийн боломжийг тэлж, эдийн засгийн төвлөрлийг бууруулах бодлого хэрэгжүүлэх.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1.Bible, E. S. (2001). *Bible*. London: Oxford University Press.

2.Klitgaard, R. (1998). *Controlling Corruption*. Berkeley, CA: University of California Press.

3.Qur'an, T. (2008). *The Qur'an*. London: Oxford University Press. .

4.Smith, P. (1994). *Assessing the Size of the Underground Economy: The Canadian Statistical Perspectives*. Canada: Canadian Economic Observer.

5.*World Justice Report*. (2024). Retrieved from <https://worldjusticeproject.org/>: <https://worldjusticeproject.org/about-us/overview/what-rule-law>

6.Александр Берзин, М. Л. (2023). *Study buddhism*. Retrieved from Study buddhism: <https://studybuddhism.com/mn/undsen-kheseg/gej-yuu-ve/yos-zui-gej-yuu-ve>

7.Алтангэрэл, О. (2024). *Авлигатай тэмцэх стратеги*. Ulaanbaatar: Мөнхийн үсэг.

8. АТГ. (2023). *Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал*. Ulaanbaatar: АТГ.

9. АТГ. (2023). *Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал*. Улаанбаатар: АТГ.

10. Верхова, Н. (2020). Электронные способы взаимодействия граждан с органами местного самоуправления. *Современное государственное и муниципальное управление: в поисках ресурсов и технологий общественного развития*., 150–151.

11. Герцик, Е. Д. (2016). Причины и условия совершения коррупционных преступлений в России. *Юридические науки: проблемы и перспективы*, 109 – 112.

12. Дамдинсүрэн, Ц. (1990). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
13. Дашгаадан, Э. О. (2022). *Криминологийн онолууд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
14. Ёс зүй, Ё. з. (2014). Нийгмийн ухаан. <https://sarangoo.blogmn.net/106873/>
15. Максимов, С. (2017). *Коррупция, закон, ответственность*. Москва, С. 120.
16. ҮСХ. (2022). *Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа*. Улаанбаатар: ҮСХ.
17. ХЗҮХ, Х. з. (2021). *Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга зам-сайн туршилага*. Ulaanbaatar: Хууль зүйн үндэсний хүрээлэн.
18. ЦХИХХЯам. (2024, 09 18). *E-Mongolia*. Retrieved from E-Mongolia: <https://ema.gov.mn/archives/4901>



МОНГОЛЫН ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН